



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Г Үнэт цаасны өмчлөх эрхийг
шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Хорооны 2007 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-ын 1.12, 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, “Буян” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 16 иргэний өмчлөл дэх “Буян” ХК-ийн нийт 8,208 /найман мянга хоёр зуун найм/ ширхэг энгийн хувьцааг өмчлөх эрхийг тэдгээрийн гаргасан хүсэлтийн дагуу бусдад шилжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

2. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэлийн журмаар шилжүүлэх ажиллагааг холбогдох журмаар тогтоосон нөхцөл шаардлага, нотлох баримтын бүрдэл, үйлчилгээний хөлсийг авах журмын дагуу гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямсүрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН